

ТАНЫ МЭДЛЭГТ

№01 2026.01.22

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗАР



Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах

1.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш **30 хоногийн дотор**, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн **02 дугаар сарын 15-ны** дотор шинэчлэн гаргаж Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

2.Мэдүүлэг гаргагч заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр **30 хоногийн дотор** мэдүүлнэ.

3.Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй, хөрөнгө орлогын мэдүүлгийг заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол гаргаж өгөөгүйд тооцно.

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН 10 ДУГААР ЗҮЙЛЭЭС . . .

ТАНЫ МЭДЛЭГТ

№02 2026.01.28

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗАР



АВЛИГЫГ МЭДЭЭЛЭХ 110 ТУСГАЙ ДУГААР **1-110** БОЛЖ ӨӨРЧЛӨГДЛӨӨ

Авлигатай тэмцэх газрын ашиглаж буй авлигыг мэдээлэх 110 тусгай дугаар **1-110** болж өөрчлөгдлөө.

Авлигатай тэмцэх газрын одоо ашиглаж буй 110 тусгай дугаарыг **2026** оны **03** дугаар сарын **01**-ний өдрийг хүртэл **давхар ажиллуулах** бөгөөд **дээрх хугацаанаас хойш 110 дугаар хаагдаж, 1-110 дугаар** ердийн горимоор урьдын адил ажиллах юм.

Иймд иргэн, албан хаагч та бүхэн авлигыг мэдээлэх шаардлагатай үед **1-110** тусгай дугаарт холбогдох боломжтой.



Авлигыг мэдээлэх утас